

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 7-р цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/167/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайшмал сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2022.02.24 № 4-6/188

танай _____ -ны № _____ -т

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮҮХДИЙН
7-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б. БОЛОРТУЛГА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 7-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 7-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан

010004

төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 43.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 413,0 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 400,1 сая төгрөгийн 29 гүйлгээ, 6,1 сая төгрөгийн 8 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 0.2 сая төгрөгийн 1 шийдвэрийн мэдээллийг огт мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 6 харилцагчдаас 6.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй, НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" заалтуудтай нийцэхгүй байна.

Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тусгай зориулалтын материалын үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй ба 0.1 сая төгрөгийн түлш шатах тослох материал тоологдоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 зорилт, 22 арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 89.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,312,369.29	182,885,111.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	43,251,355.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	43,251,355.50
3121	Төгрөг	-	43,251,355.50
31211	Төрийн сангийн харилцах	-	43,251,355.50
33	АВЛАГА	14,736,551.69	30,304.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,736,551.69	30,304.35
35	БАРАА МАТЕРИАЛ	123,575,817.60	139,603,451.60
351	Түүхий эд материал	97,514,410.00	110,583,020.00
35110	Тусгай зориулалттай материал	97,483,610.00	110,552,220.00
35130	Эм боох материал	30,800.00	30,800.00
354	Хангамжийн материал	26,061,407.60	29,020,431.60
35410	Бичиг хэргийн материал	3,411,550.00	2,124,600.00
35420	Аж ахуйн материал	7,746,180.00	8,116,620.00
35440	Түлш, шатах тослох материал	-	110,000.00
35450	Барилгын засварын материал	5,941,500.00	234,000.00
35460	Хүнсний материал	4,052,677.60	13,525,711.60
35470	Бусад хангамжийн материал	4,909,500.00	4,909,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,561,323,402.58	1,517,764,092.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,561,323,402.58	1,517,764,092.58
392	Биет хөрөнгө	1,546,849,952.54	1,503,915,642.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,461,955,025.30	1,461,955,025.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,548,875.68)	(73,097,751.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,974,540.00	93,868,450.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,328,357.08)	(23,716,449.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,281,272.88	68,931,272.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,202,899.88)	(30,365,769.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,637,930.00	7,037,930.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(178,383.00)	(956,766.00)
39217	Ном	259,700.00	259,700.00
393	Биет бус хөрөнгө	14,473,450.04	13,848,450.08
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(624,999.96)	(1,249,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,848,450.00	13,848,450.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,699,635,771.87	1,700,649,204.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,699,635,771.87	1,700,649,204.03
51	Засгийн газрын хувь оролцоо	1,699,635,771.87	1,700,649,204.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,848,450.00	13,848,450.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,685,787,321.87	1,686,800,754.03
51210	Өмнөх үеийн үр дүн	1,685,787,321.87	1,685,740,998.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,059,755.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,699,635,771.87	1,700,649,204.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	399,892,942.48	477,543,818.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,913,422.88	35,645,420.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,913,422.88	35,645,420.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,850.00	1,103,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,850.00	1,103,500.00
120009	Бусад орлого	-	1,763,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	11,182,572.88	22,340,610.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал	2,717,000.00	10,438,010.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,979,519.60	441,898,398.62
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344,267,800.00	384,159,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	384,159,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344,267,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	455,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	455,000.00	-

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,256,719.60	57,739,098.62
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,256,719.60	57,739,098.62
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	420,627,606.36	476,484,063.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,627,606.36	476,484,063.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,604,341.74	476,484,063.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,992,752.02	273,956,311.24
210101	Үндсэн цалин	192,451,697.30	218,568,886.06
210102	Нэмэгдэл	36,770,919.37	46,233,913.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,842,000.00	-
210104	Урамшуулал	19,928,135.35	9,153,511.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,575,148.54	34,848,531.71
210201	Тэтгэврийн даатгал	22,627,380.05	24,003,282.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,490,028.55	2,821,466.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,015,468.75	2,220,043.33
210204	Ажилгүйдлийн даатгал	485,560.82	519,403.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,956,710.37	5,284,335.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,022,246.60	39,909,034.06
210301	Гэрэл, цахилгаан	4,732,905.00	6,184,618.06
210302	Түлш, халаалт	29,799,000.00	31,284,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,490,341.60	2,440,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,175,430.00	2,019,060.00
210401	Бичиг хэрэг	95,000.00	1,611,600.00
210402	Тээвэр, шатахуун	310,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	223,400.00	-
210404	Ном, хэвлэл	29,430.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,184,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	332,800.00	407,460.00
2105	Нормативт зардал	10,047,398.98	40,558,646.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,450.00	-
210502	Хоол, хүнс	9,674,948.98	40,506,146.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,000.00	52,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	674,450.00	6,763,200.00
210604	Урсгал засвар	674,450.00	6,763,200.00
2107	Томилолт, зочны зардал	78,000.00	-
210702	Дотоод албан томилолт	78,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,050,000.00	435,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,050,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	435,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,988,915.60	77,994,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,700.00	7,764,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,700.00	208,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,883,515.60	70,022,220.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,023,264.62	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,823,264.62	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,823,264.62	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,734,663.88)	1,059,755.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(20,734,663.88)	1,059,755.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	385,993,369.60	443,001,898.62
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,850.00	1,103,500.00
120004	Нийтлэг татварын бус орлого	13,850.00	1,103,500.00
1200042	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,850.00	1,103,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,850.00	1,103,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,979,519.60	441,898,398.62
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344,267,800.00	384,159,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	384,159,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344,267,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	455,000.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	455,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,256,719.60	57,739,098.62
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,256,719.60	57,739,098.62
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	363,199,519.60	399,750,543.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	363,199,519.60	399,750,543.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338,176,254.98	399,750,543.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,271,789.76	259,248,004.30
210101	Үндсэн цалин	181,939,629.39	204,719,739.62
210102	Нэмэгдэл	36,595,483.19	45,574,752.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,842,000.00	-
210104	Урамшуулал	16,894,677.18	8,953,511.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,423,165.62	34,896,914.76
210201	Тэтгэврийн даатгал	22,475,397.13	24,051,452.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,490,028.55	2,826,922.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,015,468.75	2,227,955.33
210204	Ажилгүйдлийн даатгал	485,560.82	520,894.79
210205	Эрүүл мэндийн даатгал	4,956,710.37	5,269,689.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,456,719.60	39,909,034.06
210301	Гэрэл, цахилгаан	4,732,905.00	6,184,618.06
210302	Түлш, халаалт	29,233,473.00	23,843,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,490,341.60	9,881,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,694,090.00	-
210401	Бичиг хэрэг	296,700.00	-
210402	Тээвэр, шатахуун	310,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	223,400.00	-
210404	Ном, хэвлэл	75,430.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,989,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,799,160.00	-
2105	Нормативт зардал	18,631,090.00	49,981,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,800.00	-
210502	Хоол, хүнс	13,033,090.00	49,981,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,539,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.00	1,055,700.00
210604	Урсгал засвар	5,800,000.00	1,055,700.00
2107	Томилолт, зочны зардал	78,000.00	-
210702	Дотоод албан томилолт	78,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,138,100.00	460,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,138,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	460,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,683,300.00	14,199,210.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,699,860.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,683,300.00	4,499,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,023,264.62	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,823,264.62	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,823,264.62	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,793,850.00	43,251,355.50
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,780,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,780,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	22,780,000.00	-
223001	Бусад хөрөнгө	22,780,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(22,780,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13,850.00	43,251,355.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	43,251,355.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,848,450.00	1,685,787,321.87	1,699,635,771.87
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,848,450.00	1,685,787,321.87	1,699,635,771.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(46,323.45)	(46,323.45)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,848,450.00	1,685,740,998.42	1,699,589,448.42
D08	Тайлант үеийн үр дүн	-	1,059,755.61	1,059,755.61
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,848,450.00	1,686,800,754.03	1,700,649,204.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	445,517,800.00	399,750,543.12	45,767,256.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,517,800.00	399,750,543.12	45,767,256.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,517,800.00	399,750,543.12	45,767,256.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,377,900.00	259,248,004.30	39,129,895.70
210101	Үндсэн цалин	245,758,700.00	204,719,739.62	41,038,960.38
210102	Нэмэгдэл	48,241,900.00	45,574,752.98	2,667,147.02
210104	Урамшуулал	4,377,300.00	8,953,511.70	(4,576,211.70)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,339,000.00	34,896,914.76	2,442,085.24
210201	Тэтгэврийн даатгал	25,393,400.00	24,051,452.61	1,341,947.39
210202	Тэтгэмжийн даатгал	2,986,400.00	2,826,922.93	159,477.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,389,100.00	2,227,955.33	161,144.67
210204	Ажилгүйдлийн даатгал	597,300.00	520,894.79	76,405.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,972,800.00	5,269,689.10	703,110.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,184,000.00	39,909,034.06	2,274,965.94
210301	Гэрэл, цахилгаан	7,400,000.00	6,184,618.06	1,215,381.94
210302	Түлш, халаалт	31,284,000.00	23,843,200.00	7,440,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	9,881,216.00	(6,381,216.00)
2105	Нормативт зардал	50,300,000.00	49,981,680.00	318,320.00
210502	Хоол, хүнс	50,300,000.00	49,981,680.00	318,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,400,000.00	1,055,700.00	344,300.00
210604	Урсгал засвар	1,400,000.00	1,055,700.00	344,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	460,000.00	502,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	460,000.00	502,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,954,900.00	14,199,210.00	755,690.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,454,900.00	9,699,860.00	755,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,499,350.00	650.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	445,517,800.00	443,001,898.62	2,515,901.38
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	384,159,300.00	384,159,300.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	384,159,300.00	384,159,300.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,358,500.00	57,739,098.62	2,619,401.38
132001	Орон нутгийн төсвөөс	60,358,500.00	57,739,098.62	2,619,401.38
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,103,500.00	(103,500.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,103,500.00	(103,500.00)

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		43,251,355.50	(43,251,355.50)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	24.00	-
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	-
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 0.6 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. 2 хөрөнгийн ашиглалтын хугацааг оруулаагүйгээс 0.6 сая төгрөгийн элэгдэл тооцогдоогүйг залруулав.

Аудитаар нийт 5 зөрчил² илэрснээс 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 4 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 80 хувиар буюу 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 6 харилцагчдаас 6.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй, НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2. Засгийн газрын оруулсан капиталтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн УБГэрчилгээ дээрх өмчийн дүнгээс 13.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь үнэн, бодит мэдээллээр хангагдахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйл “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл”-ийн “7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн” болон 14 дүгээр зүйлийн “14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын оруулсан капиталд өөрчлөлт оруулсан тохиолдолд өөрчлөлтийн талаарх бичиг баримтыг бүрдүүлэн хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж мэдээллээ шинэчлэх.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 413.0 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 400.1 сая төгрөгийн 29 гүйлгээ, 6.2 сая төгрөгийн 8 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 0.2 сая төгрөгийн 1 шийдвэрийн мэдээллийг огт мэдээллээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

4. Тооллогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тусгай зориулалтын материалын үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр зөрсөн ба 0.1 сая төгрөгийн түлш шатах тослох материал тоологдоогүй байна. Энэ нь тооллого хийж дууссан огноогоор тооллогын үр дүнг тооцдоггүй, тайлант оны жилийн эцсийн үлдэгдлээр шууд тусгадагтай холбоотойгоор хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг бодитой, чанартай хийж, тооллогын үр дүнгээр холбогдох мэдээллүүдийг тодорхой тусгаж /хэзээ, ямар дансыг, аль өдрийн үлдэгдлээр тоолсон эсэх/ акт үйлдэж байх.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2 хөрөнгийн ашиглалтын хугацааг оруулаагүйгээс 0.6 сая төгрөгийн элэгдэл тооцогдоогүй зөрүүтэй бүртгэсэн.	1	631.3	-	-	1	631.3	1	631.3	-	-	-	-
Дүн	1	631.3	-	-	1	631.3	1	631.3	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тусгай зориулалтын материалын үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр зөрсөн ба 0.1 сая төгрөгийн түлш шатах тослох материал тоологдоогүй байна.	1						1	-				
Анхан шатны баримтын тулгалтаар 6 харилцагчдаас 6.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1						1	-				
Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн УБГэрчилгээ дээрх өмчийн дүнгээс 13.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1						1					

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 80 хувиар буюу 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	827.8	1	827.8								
Дүн	4	827.8	1	827.8			3					-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 413.0 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 400.1 сая төгрөгийн 29 гүйлгээ, 6.1 сая төгрөгийн 8 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 0.2 сая төгрөгийн 1 шийдвэрийн мэдээллийг огт мэдээллээгүй байна.	1		-	-	-	-	1	
Дүн	1		-	-	-	-	1	

